



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийг тус тус үндэслэн “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 584,190,100.46 (таван зуун наян дөрвөн сая нэг зуун ерэн мянга нэг зуун төгрөг дөчин зургаан мөнгө) төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь

1. “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2021, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний салшгүй хэсэг болох техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг заалт бүрээр ханган ажиллах, төлөвлөлтийг сайжруулах;

2.2. Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах;

2.3. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах.

3. “Амгалан дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (М.Мөнхөө)-д Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 4.2. дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ыг мөрдөж ажиллах;

3.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 591 дүгээр тогтоолыг тус тус үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;

3.3.Компанийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлд орсон нэмэлт өөрчлөлтийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр улсын бүртгэлд бүртгүүлж, дүрэмд тухай бүр оруулж байх;


3.4.Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тодотгол хийхдээ техник зохион байгуулалтын арга хэмжээ, их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дүнг худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлээр төлөвлөж буйг таслан зогсоох;

3.5.Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.2 дахь хэсэгт заасан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд” дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийх;

3.6.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар баталсан холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллах, төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, техникийн тодорхойлолтод компанийн техникийн үзүүлэлтэд тохирсон шаардлага болон тоо хэмжээг тусгаж байх;

3.7.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА		Б.ЦЭНГЭЛ
ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА		Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 02 дугаар сарын 06-ны
өдрийн ... дугаар тогтоолын хавсралт

“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИД ХИЙСЭН
ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ, ТҮҮНИЙГ АРИЛГАХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /төгрөг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	ТЗБАХ, их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур үндсэн хөрөнгө бэлтгэсэн	103,118,062.73	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3.2 дахь заалтыг мөрдөж ажиллах.
2	Үндсэн хөрөнгийг зөвшөөрөлгүй дансны ангилал хооронд шилжүүлсэн	18,303,722.73	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2.2 дахь хэсгийг мөрдөж ажиллах.
3	Шууд гэрээ байгуулахдаа Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдээгүй.	325,186,200.00	Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2023 оны А/250 дугаар тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллах.
4	Техникийн тодорхойлолтод нийцээгүй худалдан авалт	137,582,115.00	
ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НИЙТ ДҮН		584,190,100.46	(таван зуун наян дөрвөн сая нэг зуун ерэн мянга нэг зуун төгрөг дөчин зургаан мөнгө)